



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/98/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сайншанд сум 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: enkhsetseg.e@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан.....	6
2.1. Оршил .....	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	7
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал .....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.21 № 1-6/120

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.МАРТ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020090

### Аудитын гол асуудал

1. Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 онд Си Өү Эй Эл ХХК-иас нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар 55,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна. Мөн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", 25.4-т "төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх, байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно" гэж заасныг зөрчсөн байна.

2. 2019 онд түлш шатахууны зардалд 15,079.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан байхад шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь (үнэн зөв байдал, эрх ба үүрэг) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨХБҮХАТухай хуулийн 6.1 "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. 2019 оны 9-р сард цалингийн тооцооллыг буруу хийснээс 179.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь (үнэн зөв байдал) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтыг тус тус зөрчсөн байна;

Хөвсгөл сумын ЗДТГ-ын тайланд материаллаг байдлын түвшинг 13,656.1 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд илэрсэн зөрчил нь 70,259.6 мянган төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 5.1 дахин давсан байна.


### Үүрэг, хариуцлага

Хөвсгөл сумын ЗДТГазар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Ц.Март Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 16-аас 2020 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 6/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна. Уг тайлан стандартын шаардлага хангаагүйгээс засварласан тайланг 2020 оны 02 сарын 17-ны өдрийн 6/68 дугаар бүхий албан тоотоор дахин ирүүлсэн тул төлөвлөсөн хугацаандаа эцэслэн баталгаажуулж хүргэгдээгүй.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хөвсгөл сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэхэд оршино.

Хөвсгөл сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөвсгөл сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөвсгөл сумын ЗДТГазар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд асолуос программ хангамж ашигладаг байна.

Хөвсгөл сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хөвсгөл сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,361,642.7 мянган төгрөгөөс тооцон 13,616.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 13656.1 мянган төгрөгөөр тооцсон нь Төлөвлөлтийн үеийн суурь болон хувийг хэвээр авсантай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 250,611.0 мянган төгрөгөөр буюу 22.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,274.6	4,206.6	-68.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	25,441.1	40,260.5	14,819.4
Үндсэн хөрөнгө	1,084,727.0	1,324,169.8	239,442.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,118,205.9</b>	<b>1,368,816.9</b>	<b>250,611.0</b>
Өр төлбөр	14,463.6	3,205.9	-11,257.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,103,742.4	1,365,610.9	261,868.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,118,205.9</b>	<b>1,368,816.9</b>	<b>250,611.0</b>

Авлага дансны эхний үлдэгдэл бүгд барагдсан бөгөөд тайлант онд шатахууны авлага 1408.8 мянган төгрөг, цалин илүү олгосон 179.9 мянган төгрөг, нэмэлт дансны үлдэгдэл төврүүлсэн 2797.7 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацааны нүүрсний үлдэгдэл 8,095.1 мянган төгрөг, мал нас дэвшүүлэн бүртгэсэн 11,577.1 мянган төгрөг болж өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ОНХСангаар хийгдсэн ажил болон хандивын хөрөнгө 248,489.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1909.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөнд ОНХСангаас хийгдсэн Ахмадын соёл үйлчилгээний төвийн барилга 119,000.0 мянган төгрөг, Жавхлант багийн төвийн барилга 31,489.6 мянган төгрөг, Ногоон

байгууламж 6010.8 мянган төгрөг, төв талбай 26.0 сая төгрөг байна. Харин Нутгийн зөвлөлөөс 33,000.0 мянган төгрөгийн фургон автомашин үнэ төлбөргүй ирсэн байна.

Үндсэн хөрөнгөөс 2-р багт байрлах хоолны газрын 1419.6 мянган төгрөгийн барилга, 7000,0 мянган төгрөгийн хашаа, 15119.0 мянган төгрөгийн багийн дарга нарын мотоцикл, 11,144.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил болон тоног төхөөрөмжийг ИТХ-ын тогтоолоор акталж нийт 34683.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнө оны интернэтийн төлбөр 10560.0 мянган төгрөгийн өрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,365,610.9 мянган төгрөг болж 261,868.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Хөвсгөл сумын ЗДТГазар нь тайлант онд 308,647.1 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 308,367.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Санхүүжилтийн орлого төгрөг/

/мянган

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,147.1	308,228.1	81.0	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	592.0	92.0	118.4
<b>Нийт дүн</b>	<b>308,647.1</b>	<b>308,820.1</b>	<b>173.0</b>	<b>100.0</b>

Орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 81.0 мянган төгрөгөөр илүү санхүүжсэн байна. Харин үндсэн үйл ажиллагааны орлого 92.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 308,647.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 308,647.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 308,147.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 1.5-д харуулав.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээр байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 38.1 мянган төгрөгөөр, Томилолтын зардал 218.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 19.4 мянган төгрөгөөр, Бараа ажил үйлчилгээний бусад зардал 2.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Нийт зардал 279.5 мянган төгрөгөөр хэмнэгдэж, санхүүжилт 173.0 мянган төгрөгөөр илүү орж нийт 452.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив 55,000.0 мянган төгрөг, Түрээсийн орлого 3073.4 мянган төгрөг, СЗДТГ-аас өвс тэжээлийн үнэ болон Олон нийтийн цагдаагийн зардалд 42,769.5 мянган төгрөг нийт 100,842.9 мянган төгрөг төвлөрүүлж, шатахуунд 2600.9 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 46354.4 мянган төгрөг, Бараа ажил үйлчилгээний бусад зардалд 47838.5 мянган төгрөг, нэг удаагийн шагнал урамшууллын зардалд 1251.2 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 2797.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 74,342.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,082.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 179.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 15,079.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 55,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 70,259.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 15,259.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Түлш шатахууны зардал 15079.7 мянган төгрөг батлагдсан байхад тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 7-р зүйл, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байх тухай албан шаардлага өгөх

2. 9-р сард цалинг тооцохдоо 179.9 мянган төгрөг илүү тооцож олгосон нь нь Монгол Улсын төсвийн тухай хуулийн 16.5.2 заалт, үнэн зөв байдал болон хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг төлүүлэх төлбөрийн акт тогтоох

3. Авлага өглөгийн тооцооны үлдэгдлийн баталгаа хийгээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 заалт болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийн баталгааг харилцагч бүрээр хийж байх албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 55,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төлөвлөгөөнөөс давсан түрээсийн орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хөвсгөл сумын ЗДТГазар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12.5 сая төгрөгийн зөрчилд 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос барагдаагүй байна.

Нийт 12.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Хөвсгөл сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Си Өй Эй Эл ХХК-аас нэмэлт харилцах дансаар хандив авч зарцуулсан

1.2. Эрсдэл: *Ашиг сонирхлын зөрчил үүсэх*

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 60.2.5 “Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”-д заасны дагуу хандив, тусламжийг ОНХСанд төвлөрүүлэн зарцуулж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Бичгээр өгсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>33,478,874.09</u></b>	<b><u>44,647,082.54</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,274,646.00	4,386,556.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	179,931.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	4,274,646.00	4,206,625.00
3351	Байгууллагаас авах авлага	4,274,646.00	4,206,625.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	25,441,128.09	40,260,526.54
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,180,908.09	28,683,406.54
35410	Бичиг хэргийн материал	757,750.00	1,004,000.00
35420	Аж ахуйн материал	10,789,897.59	14,213,317.59
35440	Түлш, шатах тослох материал	2,336,260.50	8,095,088.95
35450	Барилгын засварын материал	1,897,000.00	1,747,000.00
35460	Хүнсний материал	00.00	26,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,400,000.00	3,598,000.00
35600	Мал амьтад	7,260,220.00	11,577,120.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,084,727,053.33</u></b>	<b><u>1,324,169,792.42</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,084,727,053.33	1,324,169,792.42
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	995,103,011.72	1,234,582,209.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	480,034,438.96	635,104,438.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,336,825.55	-14,917,225.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,793,800.00	161,674,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,638,794.52	-91,340,644.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	148,812,029.08	143,220,035.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,491,298.06	-113,668,417.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,610,595.39	49,052,178.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,971,834.24	-20,752,606.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	856,921,432.60	917,371,432.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-436,630,531.94	-431,161,781.69
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	89,624,041.61	89,587,583.26
39301	Програм хангамж	1,633,500.00	1,633,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,407,458.39	-1,443,916.74
39303	Бусад биет бус хөрөнгө	89,398,000.00	89,398,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>1,118,205,927.42</u></b>	<b><u>1,368,816,874.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>14,463,560.00</u></b>	<b><u>3,205,901.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	14,463,560.00	3,205,901.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	14,463,560.00	3,205,901.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,248,406.00	1,251,250.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,560,000.00	177,551.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,655,154.00	1,777,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,580,000.00	1,694,000.00

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	75,154.00	83,100.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,103,742,367.42</u></b>	<b><u>1,365,610,973.96</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,103,742,367.42	1,365,610,973.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,405,764,735.81	1,405,764,735.81
51101	Өмч: - төрийн	1,405,764,735.81	1,405,764,735.81
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-465,059,775.12	-203,191,168.58
51210	Өмнөх үеийн үр дүн	-465,059,775.12	-463,999,775.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	260,808,606.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	163,037,406.73	163,037,406.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,118,205,927.42</u></b>	<b><u>1,368,816,874.96</u></b>

## 1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>321,202,407.05</b>	<b>664,293,430.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,546,149.00</b>	<b>232,586,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	33,296,149.00	49,800,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,296,149.00	49,800,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	584,590.00	592,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,811,559.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,900,000.00	49,208,100.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	8,250,000.00	182,786,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	8,250,000.00	182,786,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>279,656,258.05</b>	<b>431,707,330.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,784,448.05	98,479,230.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,784,448.05	17,688,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	80,790,460.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	253,871,810.00	333,228,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,871,810.00	308,228,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	00.00	25,000,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	00.00	25,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>446,111,300.09</b>	<b>404,290,423.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>366,586,300.08</b>	<b>404,290,423.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	366,538,474.08	402,522,893.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	198,052,220.83	203,847,912.00
210101	Үндсэн цалин	198,052,220.83	203,847,912.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,505,469.45	26,403,060.08
210201	Тэтгэврийн даатгал	12,731,006.00	18,689,260.08
210202	Тэтгэмжийн даатгал	1,139,117.00	1,542,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,079,461.00	1,928,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	266,380.00	385,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,289,505.45	3,856,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,345,849.05	7,777,591.00
210301	Гэрэл, цахилгаан	3,379,699.05	3,432,791.00
210302	Түлш, халаалт	1,541,050.00	4,061,600.00
210303	Цэвэр, бохир ус	425,100.00	283,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	46,781,470.43	46,246,351.55
210401	Бичиг хэрэг	3,302,505.00	4,822,290.00

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГазрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	8,464,183.00	15,600,071.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,239,351.00	9,984,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,593,231.43	15,839,990.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	362,600.00	2,346,020.00
210502	Хоол, хүнс	360,300.00	2,283,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,300.00	62,920.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,902,741.00	5,053,290.00
210604	Урсгал засвар	1,652,741.00	5,053,290.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,812,700.00	4,420,260.00
210702	Дотоод албан томилолт	3,812,700.00	4,420,260.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,148,765.30	51,909,846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,161,777.30	50,850,646.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	817,000.00	237,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,000.00	273,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	72,800.00	75,600.00
210807	Газрын төлбөр	530,188.00	256,440.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,626,658.02	54,518,562.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,859,472.00	31,827,122.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	198,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,767,186.02	22,493,440.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,826.00	1,767,529.92
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,826.00	1,315,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,315,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	452,529.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	452,529.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-124,908,893.04</b>	<b>260,003,006.54</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	805,600.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	805,600.00
225009	Дамжуулан зээлдүүлэх зээл		
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-318,849,185.65	805,600.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-443,758,078.69</b>	<b>260,808,606.54</b>

### 1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>298,406,378.05</u></b>	<b><u>409,662,976.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,721,303.00</b>	<b>592,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,471,303.00	592,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,471,303.00	592,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	584,590.00	592,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	8,250,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	8,250,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>279,685,075.05</b>	<b>409,070,976.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,784,448.05	100,842,876.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,784,448.05	17,688,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	83,154,106.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	253,871,810.00	308,228,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,871,810.00	308,228,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	28,817.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	28,817.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>298,066,378.05</u></b>	<b><u>409,662,976.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>298,066,378.05</b>	<b>409,662,976.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>295,675,697.93</b>	<b>404,861,489.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	190,350,923.28	205,042,199.59
210101	Үндсэн цалин	183,357,919.28	205,042,199.59
210104	Урамшуулал	6,993,004.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,756,500.00	26,305,299.49
210201	Тэтгэврийн даатгал	15,171,000.00	18,591,499.49
210202	Тэтгэмжийн даатгал	1,896,400.00	1,542,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,517,100.00	1,928,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	379,300.00	385,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,792,700.00	3,856,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,657,400.00	11,375,240.00
210301	Гэрэл, цахилгаан	2,870,900.00	3,255,240.00
210302	Түлш, халаалт	4,361,500.00	7,818,000.00
210303	Цэвэр, бохир ус	425,000.00	302,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,609,358.60	41,264,973.00
210401	Бичиг хэрэг	2,565,872.60	3,450,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,783,215.00	17,680,653.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,340,271.00	19,484,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,000.00	649,520.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,423,360.00	200,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,500.00	00.00
210502	Хоол, хүнс	899,860.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,019,500.00	3,999,471.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,000,000.00
210602	Тавилга	5,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,019,500.00	1,999,471.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,812,700.00	4,420,260.00
210702	Дотоод албан томилолт	3,812,700.00	4,420,260.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,398,633.00	59,217,521.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,417,445.00	58,158,321.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	817,000.00	237,960.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,000.00	273,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,000.00	75,600.00
210807	Газрын төлбөр	530,188.00	256,440.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,647,323.05	53,036,525.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,647,323.05	52,838,525.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	198,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,390,680.12</b>	<b>4,801,486.92</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	842,854.12	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	842,854.12	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,547,826.00	1,551,165.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	47,826.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,000,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,551,165.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	2,797,792.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,797,792.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	452,529.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	452,529.92
213504	Хөрөнгийн	00.00	00.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>340,000.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	340,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	340,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	340,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	340,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-340,000.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,316,366,735.81	117,999,348.47	-8,620,245.52	1,425,745,838.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	31,622.00	31,622.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,316,366,735.81</b>	<b>117,999,348.47</b>	<b>-8,588,623.52</b>	1,425,777,460.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	89,398,000.00	00.00	-443,758,078.69	-354,360,078.69
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>163,037,406.73</b>	<b>-465,059,775.12</b>	1,103,742,367.42
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>163,037,406.73</b>	<b>-465,059,775.12</b>	1,103,742,367.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,060,000.00	1,060,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>163,037,406.73</b>	<b>-463,999,775.12</b>	1,104,802,367.42
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	260,808,606.54	260,808,606.54
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,405,764,735.81</b>	<b>163,037,406.73</b>	<b>-203,191,168.58</b>	<b>1,365,610,973.96</b>

### 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	308,647,100.00	308,367,570.08	279,529.92	99.91
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	308,647,100.00	308,367,570.08	279,529.92	99.91
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	308,347,100.00	308,067,570.08	279,529.92	99.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	205,042,200.00	205,042,199.59	0.41	100.00
210101	Үндсэн цалин	205,042,200.00	205,042,199.59	0.41	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,305,300.00	26,305,299.49	0.51	100.00
210201	Тэтгэврийн даатгал	18,591,500.00	18,591,499.49	0.51	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,542,800.00	1,542,800.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,500.00	1,928,500.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	385,700.00	385,700.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,856,800.00	3,856,800.00	0.00	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,413,400.00	11,375,240.00	38,160.00	99.67
210301	Гэрэл, цахилгаан	3,256,400.00	3,255,240.00	1,160.00	99.96
210302	Түлш, халаалт	7,855,000.00	7,818,000.00	37,000.00	99.53
210303	Цэвэр, бохир ус	302,000.00	302,000.00	0.00	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,664,500.00	38,664,020.00	480.00	100.00
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	3,450,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	15,079,700.00	15,079,700.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,484,000.00	19,484,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00	649,520.00	480.00	99.93
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	200,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,000,000.00	3,999,471.00	529.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,471.00	529.00	99.97
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,639,200.00	4,420,260.00	218,940.00	95.28
210702	Дотоод албан томилолт	4,639,200.00	4,420,260.00	218,940.00	95.28
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,882,500.00	12,863,080.00	19,420.00	99.85

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ЗДТГазрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,741,000.00	11,803,880.00	-62,880.00	100.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	220,000.00	216,000.00	4,000.00	98.18
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	237,960.00	62,040.00	79.32
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,000.00	273,200.00	3,800.00	98.63
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	75,600.00	12,400.00	85.91
210807	Газрын төлбөр	256,500.00	256,440.00	60.00	99.98
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5200000.00	5198000.00	2,000.00	99.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	198,000.00	2,000.00	99.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	300000.00	300000.00	0.00	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	300,000.00	300,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	308,647,100.00	308,820,100.00	-173,000.00	100.06
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	308,147,100.00	308,228,100.00	-81,000.00	100.03
132001	Орон нутгийн төсвөөс	308,147,100.00	308,228,100.00	-81,000.00	100.03
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	500,000.00	592,000.00	-92,000.00	118.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	592,000.00	-92,000.00	118.40
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	09.00	1.00	90.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	09.00	-1.00	112.50

### 1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>100,842,876.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>100,842,876.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	96,793,919.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,600,953.00
210402	Тээвэр, шатахуун	2,600,953.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	46,354,441.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,354,441.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47838525.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47838525.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1251165.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,251,165.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,251,165.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,797,792.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,797,792.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	100842876.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	100,842,876.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,688,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,154,106.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	